



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/ЖО

Хэрлэн сум

Мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.12 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд зудын гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмээс хүн, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал, амьтны сэг, зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийг мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох журам, зааврын дагуу орон нутгийн байгууллага, малчид, иргэдийн оролцоотой шуурхай зохион байгуулж, хүн хүч, шаардагдах зардал, тээврийн хэрэгслийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Мал, амьтны сэг, зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар дарга (Н.Анхбаяр), Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Мөнх-Эрдэнэ) нарт даалгасугай.

4.Мал, амьтны сэг зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээнд ажилгүй иргэдийг татан оролцуулах, түр ажлын байраар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, төсөл хөтөлбөрийн хүрээнд ажлын хөлсийг холбогдох журмын дагуу олгохыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар (Э.Хонгорзул)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ